

БАГА БОЛОВСРОЛЫН  
ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ  
ШАЛГУУРЫГ ХЭРЭГЛЭХ ЗӨВЛӨМЖ

**ХҮН БА НИЙГЭМ**





БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ  
ЯАМ



THE WORLD BANK  
IBRD • IDA | WORLD BANK GROUP



ASIAN  
DEVELOPMENT  
BANK



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ  
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

БАГА БОЛОВСРОЛЫН  
ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ  
ШАЛГУУРЫГ ХЭРЭГЛЭХ

# ЗӨВЛӨМЖ

ХҮН БА НИЙГЭМ

*АНХНЫ ХЭВЛЭЛ*

УЛААНБААТАР 2021



## **ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

---

Суралцагчийн үнэлгээ..... 2

## **БАГА БОЛОВСРОЛЫН ТҮВШИН**

---

Нэг. Хүн ба нийгэм хичээлийн үнэлгээний шалгуурыг боловсруулсан нь ..... 5

Хоёр. Үнэлгээний шалгуурыг ашиглан нэгжийн үр дүнг илрүүлэх  
үнэлгээний даалгавар боловсруулах нь .....10

Гурав. Үнэлгээний даалгаврын гүйцэтгэлийг шинжлэх, шинжилгээний  
үр дүнг ашиглах нь.....18

## СУРАЛЦАГЧИЙН ҮНЭЛГЭЭ

Боловсролын үнэлгээний нэг чухал хэсэг нь суралцагчийн үнэлгээ юм. Энэ нь суралцагчийн суралцах үйл ажиллагаа /суралцахуй/-ны талаарх мэдээлэл цуглуулах, сайжруулах, шаардлагатай тохиолдолд шийдвэр гаргах зорилгоор системтэй мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт хийх үйл явц юм. Багш нар хичээл сургалтын явцад суралцагчийг үнэлж журналд дүн тавих, нэгж, бүлэг сэдвийн дараа шалгалт /сорилго<sup>1</sup>/ авах, засаж оноожуулах /хэмжилт хийх<sup>2</sup>/, үнэлж дүгнэх<sup>3</sup> зэрэг байнга хийдэг ажил нь үнэлгээний үйл явцад хамаарна.

Бид үнэлгээний шалгалт авах, дүн тавих үйл явцыг хийдэг боловч шалгалтаар дамжуулан суралцахуйн талаар ямар ач холбогдолтой мэдээлэл цуглуулж буй, үр дүнд шинжилгээ хийх, шинжилгээний үр дүнг сургалтын үйл ажиллагаанд бүтээлчээр хэрэглэх байдлыг орхигдуулж ирсэн. Суралцагчийн үнэлгээг зөвхөн дүн тавихын тулд хийж ирсэн тогтсон ойлголт, хандлагыг өөрчлөх хэрэгцээ байна.

Суралцагчийн үнэлгээ гэдэгт “суралцагчийн сурлагын амжилтын түвшнийг тогтоох, мэдлэг, чадвар, хандлага төлөвшлийн ахиц, өөрчлөлтийг бодитой үнэлэх, түүнд тулгарч буй бэрхшээлийг илрүүлж дэмжлэг үзүүлэх, урамшуулах үйл явц”-ыг ойлгоно.

Хичээл, сургалтын өдөр тутмын болон тодорхой хугацааны /бүлэг сэдэв, хагас жил, жилийн эцэс/ дараа хийдэг бүх төрлийн үнэлгээ **“шалгуур”**-г суурилсан байна.

### ШАЛГУУРТ СУУРИЛСАН ҮНЭЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР

Багш нарын хувьд **“үнэлгээ”**-г шалгуурт суурилсан байдлаар үр дүнтэй хийхийн тулд үнэлгээний шалгуур болон шалгуурт суурилсан үнэлгээний талаарх мэдлэг ойлголтоо өргөжүүлэн гүнзгийрүүлэх шаардлагатай.

Суралцахуйн үр дүнд эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага төлөвшилд баримжаалж боловсруулсан тодорхой шалгуур (хүрэх үр дүн)-тай харьцуулж суралцагчийн сурлагын амжилтыг үнэлэх үйл явцыг шалгуурт суурилсан үнэлгээ /criterion referenced assessment/ гэдэг. Өөрөөр хэлбэл суралцагчийн гүйцэтгэлийг бусад суралцагчтай бус зөвхөн үнэлгээний шалгууртай харьцуулж үнэлж, дүгнэх үйл явц гэсэн үг.

Үнэлгээний шалгуур нь:

- Суралцахуйн үр дүнд нийцсэн сурагчийн гүйцэтгэлийг хэрхэн тодорхойлохыг зааж өгдөг.
- Сурагч суралцахуйн үр дүнг амжилттай эзэмшсэнийг харуулахын тулд юуг хийж чадаж байгаагийн товч илэрхийлэл
- Суралцахуйн үр дүн бүрийг эзэмшсэн байх тодорхой, хоёрдмол утгагүй нотолгоог бий болгох зорилготой.

<sup>1</sup> Сорилго нь бүх суралцагчдыг тодорхой хугацааны дараа зохион байгуулдаг, асуултын багцаас тогтсон үнэлгээний тодорхой төрөл юм. Сорилго нь тоон болон ямар нэг ангиллын хэмжээсийг ашиглан суралцагчийн нэг ба хэд хэдэн шинж чанарыг хэмжих, илэрхийлэх гэсэн системтэй арга хэрэгсэл юм.

<sup>2</sup> Хэмжилт нь сорилго, эсвэл үнэлгээний төрлийн үр дүнг тусгай дүрэм (жишээлбэл, зөв хариулыг тоолох, оноо өгөх г.м)-ийн дагуу тоогоор илэрхийлдэг. Ихэнхдээ оноо өгөх /scoring/ гэж тодорхойлдог.

<sup>3</sup> Үнэлгээний мэдээллийг хэрэглэн, тогтсон шалгуур үзүүлэлтэд харгалзах чансааг тодорхойлох үйл явц

Өөрөөр хэлбэл, үнэлгээний шалгуур гэдэг нь сургалтын явцад суралцагч бүрийн эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага төлөвшил буюу хүрэх үр дүн юм.

Үнэлгээний шалгуур нь дараах ач холбогдолтой. Үүнд:


- Суралцагчийн сурлагын амжилтыг үнэлж, дүгнэх ижил хэмжүүрийг тодорхой, ил тод болгох.
- Үнэлгээг зөв, бодитой хийх боломж бүрдэх.
- Даалгавар боловсруулахад баримжаа болох.
- Тухайн суралцагчийн суралцахуйн давуу, сул тал, тулгамдаж буй бэрхшээлийн талаарх мэдээллийг цуглуулах.
- Суралцахуйн арга зүйг төлөвлөх, хэрэгжүүлэх замаар багшлахуйг сайжруулах боломжийг бүрдүүлэх.
- Суралцагчийг ижил шалгуураар үнэлж, тэдний ахиц амжилт, өөрчлөлтийг хянах боломж олгох.

Үнэлгээний шалгуур нь дараах шаардлагад<sup>4</sup> нийцсэн байна. Үүнд:


- Боловсролын түвшин, анги, судлагдахуун бүрээр залгамж холбоотой, эрэмбэ ахисан байх
- ЕБС-ийн багш нар шууд авч ашиглах боломжтой байхаар боловсруулсан байх
- Оролцогч бүх тал /суралцагч, багш, эцэг эх, асран хамгаалагч гэх мэт/-д ойлгогдохоор товч тодорхой, оновчтой энгийн үг хэллэгээр бичсэн байх
- Давхцалгүй, нэг нэгнээсээ ялгаатай байх
- Суралцагчдад юу хийхийг тодорхой ойлгуулахуйц үйл /түлхүүр үг/ үгсийг ашигласан байх. Жишээ нь: эмхэтгэх, бий болгох, бүтээх, төлөвлөх, дахин боловсруулах, шинжлэх, дизайн хийх, сонгох, ашиглах, хэрэглэх, үзүүлэх, бэлтгэх, ашиглах, тооцоолох, тайлбарлах, урьдчилан таамаглах, харьцуулах, шүүмжлэх гэх мэт
- Сурагчийн гүйцэтгэл нь ажиглагдахуйц, хэмжигдэхүйц байхаар үг сонгох

## ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУРЫН БҮТЭЦ

Ерөнхий боловсролын сургуулийн түвшинд хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүнд тулгуурлан дараах бүтэцтэйгээр боловсруулсан.



<sup>4</sup> Эх сурвалж: Боловсролын салбарын хөгжил-Боловсролын чанарт нөлөөлж буй сургуулийн хүчин зүйлс” судалгааны эцсийн тайлан, 1.14 дэх бүлэг. Азийн хөгжлийн банкны техник туслалцааны төсөл, 2017 он.






## Нэг. Хүн ба нийгэм хичээлийн үнэлгээний шалгуур

Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам<sup>1</sup>д зааснаар “Суралцагчийн үнэлгээ нь оношлох, явцын, үр дүнгийн гэсэн төрөлтэй байх бөгөөд үнэлгээ нь шалгуурт суурилсан байна. “Шалгуурт суурилсан үнэлгээ” нь сурагчийн амжилтын түвшний хүрэх үр дүнтэй харьцуулан үнэлэхэд чиглэнэ. Хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг боловсролын түвшин, анги, хичээл бүрээр боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага, боловсролын үнэлгээний байгууллага хамтран боловсруулж, батална.” гэжээ.

Энэхүү журмыг хэрэгжүүлэх үүднээс “Хүн ба нийгэм” хичээл, сургалтын үнэлгээний шалгуурыг хэрэгжүүлэх зөвлөмжийг хүргэж байна. Энэхүү зөвлөмж нь хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг хэрэглэхэд багшид арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилготой. Багш та бүхэн шалгуурыг боловсруулахад баримталсан арга зүй, холбогдох тулгуур ойлголт, нэр томъёотой сайтар танилцах нь уг шалгуурыг үр дүнтэй хэрэгжүүлэх боломжтой болохыг анхаарна уу.

Зураг 1. Үнэлгээний шалгуур боловсруулсан үйл явц



<sup>1</sup> Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн А/425 дугаар тушаалын хавсралт

Үнэлгээний шалгуурыг боловсруулахын тулд “Бага боловсролын сургалтын хөтөлбөр”-ийн Хүн ба нийгмийн суралцахуйн зорилтуудыг үнэлгээний нэгжид багцлаад, багцалсан нэгжийн хүрээнд тухайн анги бүрийн суралцахуйн зорилтыг хэрэгжүүлснээр сурагчийн эзэмшсэн байх үр дүнг (Суралцахуйн үр дүн) тодорхойлсон. Үүний үндсэн дээр суралцахуйн үр дүн (СҮД) тус бүрийг эзэмшсэн эсэхийг илрүүлэх шалгуур боловсруулаад тухайн шалгуур бүрийн гүйцэтгэлийн түвшний рубрукээр харуулсан болно.

### Хүснэгт 1. Үнэлгээний шалгуур (тоогоор)

	Анги	
	IY	Y
Үнэлгээний нэгж	3	6
Суралцахуйн үр дүн	4	8
Суралцахуйн үр дүнгийн шалгуур	10	15

Сургалтын хөтөлбөрийн суралцахуйн зорилтуудыг үнэлгээний нэгжид багцалсан. Ингэхдээ дараах арга замыг ашиглалаа. Үүнд:

- Нийгмийн бүлгийн хамрах хүрээгээр багцлах;
- Түүхэн цаг хугацааны дагуу түүхийн үйл явдлаар багцлах;
- Агуулгын хувьд бүгдийг бус цөм (чухал) суралцахуйн зорилтын хэрэгжилтийг илрүүлэхүйц байх зэрэг болно.

Үнэлгээний нэгж нь СҮД-г илрүүлэх шалгуур боловсруулахад зориулсан нэгж бөгөөд зарим үнэлгээний нэгж нь нэгж хичээлийн сэдэвтэй давхцаж болохыг анхаарах хэрэгтэй. Тухайлбал, сургалтын хөтөлбөрийн IV ангийн Би, гэр бүл, сургуулийн амьдрал, үйл ажиллагаанд оролцохтой холбогдох хэд хэдэн суралцахуйн зорилт (4.1а, 4.1б, 4.2г, 4.3а)-ыг үнэлгээний 1 нэгж болгосон. Үүнд:

- “Бидний оролцоо, хувь нэмэр” гэсэн нэгжийн хүрээнд сурагч “Гэр бүл, сургууль, орон нутгийнхаа үйл ажиллагаанд санаа, хүсэлтээ илэрхийлэх, удирдан зохион байгуулах зэргээр хувь нэмрээ оруулна” гэж СҮД-г тодорхойлж, уг СҮД-г илрүүлэх шалгуурыг тогтоосон.
- ✓ Үнэлгээний нэгж тус бүрийн хүрээнд СҮД-г тодорхойлж, уг СҮД-г илрүүлэх шалгуурыг:
  - Өөрийн харьяалагдаж буй гэр бүл, анги хамт олныхоо өмнө хүлээж буй үүрэг хариуцлагаа танилцуулах;
  - Түүхэнд болон орон нутагтаа гавьяа байгуулсан хүмүүсийн намтрыг бичих, танилцуулах гэх мэтээр тогтоосон.

Зураг 2. Үнэлгээний нэгж болон СҮД, түүний шалгуурын жишээ

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. БАГА БОЛОВСРОЛ				
1.1 IV АНГИЙН ХИЧЭЭЛ СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР				
1.1.1. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ, СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН (СҮД) БА ШАЛГУУР				
№	Суралцахуйн зорилт код	Нэгж	Суралцахуйн үр дүн (СҮД)	СҮД-ийн шалгуур
1.	4.1а. Гэр бүлийн орчинд өөрийн бодол санаа, хүсэлтээ илэрхийлэн харилцах 4.1б. Сургууль, анги дахь өөрийн оролцоог тодорхойлох 4.2г. Сурагч нутгийнхаа нийгмийн амьдралд өөрийн хувь нэмэр оруулах 4.3а. Хүмүүсийн амьдрал, үйл ажиллагаанд идэвхтэй оролцох	Бидний оролцоо, хувь нэмэр	Гэр бүл, сургууль, орон нутгийнхаа үйл ажиллагаанд санаа, хүсэлтээ илэрхийлэх, удирдан зохион байгуулах зэргээр хувь нэмрээ оруулна.	Гэр бүлдээ үүрэг, хариуцлага хүлээж, хувь нэмэр оруулдаг болохоо танилцуулдаг. Ангийн хурал, урлаг, спортын арга хэмжээ зэрэг сургууль, анги хамт олны үйл ажиллагаанд оролцох арга замыг тодорхойлдог. Хүүхдүүдэд зориулан зохион байгуулж буй орон нутгийн арга хэмжээнд оролцдог.


Эх сурвалж: “Түүхийн хичээл сургалтын үр дүнг үнэлэх шалгуур”.

СҮД-ийн шалгуурын хэрэглээ, ач холбогдлыг дараах байдлаар тодорхойлох боломжтой. Үүнд:

- Үндэсний болон орон нутгийн, нэгж, сургууль бүр бага боловсролын сургалтын хөтөлбөрт нийцсэн “Даалгаврын нээлттэй сан” бүрдүүлэхдээ даалгаварт тавих шалгуур болгон ашиглах (даалгаврын сан үүсгэх);
- Багш болон сурагч, бусад хэрэглэгчид бага боловсролын сургалтын хөтөлбөрийг судалснаар хүрэх суралцахуйн үр дүнгийн талаар нэгдсэн ойлголттой болох;
- Хөндлөнгийн болон өөрийн үнэлгээ хийх талууд нэгдсэн шалгуурыг баримтлах;

§ Эцэст нь СҮД-ийн шалгуурын дагуу сурагчийн гүйцэтгэлийг I-IV түвшнээр илрүүлэхэд ашиглах үзүүлэлтийг гаргалаа. Энэхүү үзүүлэлтийг СҮД-ийн шалгуурын дагуу боловсруулсан даалгаврыг сурагчид ямар түвшинд гүйцэтгэж буйг илрүүлэхэд ашиглана. Ингэснээр сурагчдыг оношилж, тэдэнд дэмжлэг үзүүлэх, суралцахуйд нь туслах арга замыг илүү тодорхой болгох ач холбогдолтой.

Зураг 3. СҮД-ийн шалгуур болон гүйцэтгэлийн түвшний үзүүлэлтийн тайлбар



Багш СҮД-ийн шалгуурын болон уг шалгуурын гүйцэтгэлийн түвшний үзүүлэлт хоорондын холбоо, танин мэдэхүйн түвшинг анхаарах хэрэгтэй. Тухайлбал, СҮД-ийн шалгуур нь “Гэр бүлдээ үүрэг, хариуцлага хүлээж, хувь нэмэр оруулдаг болохоо танилцуулдаг.” гэсэн бол гүйцэтгэлийн бүх түвшинд “танилцуулга хийх” үзүүлэлт байх ёстой гэсэн үг. Харин СҮД-ээр сурагч гэр бүлдээ үүрэг, хариуцлага хүлээж, хувь нэмрээ оруулах, оролцоо зэргийг “танилцуулдаг” болсон байх учиртай байтал гүйцэтгэлийн үзүүлэлтийг “нэрлэдэг, ангилдаг” гэсэн бол энэ нь СҮД-ийн шалгуурын болон гүйцэтгэлийн үзүүлэлтийн түвшин зөрчилдсөн болно гэсэн үг. Өөрөөр хэлбэл, СҮД нь танин мэдэхүйн аль түвшинд тодорхойлогдсон байна, гүйцэтгэлийн үзүүлэлт нь тухайн түвшиндөө гарсан байхаар боловсруулсныг сайтар ойлгох нь чухал юм.

СҮД-ийн шалгуурын болон гүйцэтгэлийн үзүүлэлтийн холбоог энэхүү зөвлөмжийн дараагийн хэсэгт орсон жишиг даалгавруудаар харуулахыг хичээсэн болно.

Даалгавар боловсруулах, сурагчдын гүйцэтгэлийг үнэлэхдээ СҮД-ийн шалгуур болон гүйцэтгэлийн түвшин үзүүлэлттэй холбоотой нэр томъёог нэгэн утгаар хэрэглэх нь чухал. Тухайлбал, хүн ба нийгэм хичээлээр сурагчдын хүрсэн байх гол үр дүн бол би, гэр бүл, сургууль, орон нутгийнхаа үйл ажиллагаанд хувь нэмэр оруулах, орон нутгийнхаа үйлдвэр, үйлчилгээний байгууллагын онцлогийг тайлбарладаг, танилцуулдаг (explanation; explain) болсон байх юм. Тайлбарлах (explanation; explain) нь ойлголт, учир шалтгааны талаарх мэдлэгээ хэрэглэж, жишээгээр мэдээллэх явдал бөгөөд сурагчдын сэргээн санах, ойлгох заримдаа хэрэглэх түвшний мэдлэг чадварыг эзэмшсэнийг илэрхийлдэг. Шалгуур болон гүйцэтгэлийн түвшин, үзүүлэлтийг нэгэн утгаар ойлгосноор даалгавар боловсруулах, сурагчдыг бодитой, шударга үнэлэх боломжтой болно. Мөн даалгаврын гүйцэтгэлд шинжилгээ хийж, сурагчдад дэмжлэг үзүүлэх, хичээл төлөвлөлт, хэрэглэгдэхүүн зэргийг сайжруулахад тустай юм. Нэр томъёоны тайлбарыг хийхдээ сургалтын хөтөлбөр болон монгол хэлний тайлбар толь бичиг зарим улс орны түүх, нийгмийн ухааны сургалтын үнэлгээнд хэрэглэдэг гүйцэтгэлийн үзүүлэлт зэрэг эх сурвалжийг ашиглалаа.

## Хүснэгт 2. Үнэлгээнд хэрэглэх зарим нэр томъёоны тайлбар

Нэр томъёо	Тайлбар
Оновчтой, бүрэн	Нарийвчилсан, тодорхой, стандарт, дүрэм, журам болон бусад баримтын дагуу, бүх талаар зөв байх
Шинжилгээ (анализ) хийх	Утга учир, уялдаа холбоог олж тогтоох, зүй тогтол, адил болон ялгаатай талыг илрүүлэхийн тулд бүх талыг нарийвчлан харгалзаж үзэх
Хүчин зүйлс	Тухайн түүхэн болон нийгмийн үйл явдалд гол нөлөө үзүүлсэн, улс орны дотоод болон гадаад улс, дэлхий дахинд болсон, өрнөсөн үйл явдал
Учир шалтгаан, үр дагавар	Түүхчид цаг хугацааны туршид, богино болон урт хугацааны үйл явдлын хэлхээ, гинжин өрнөлийг тогтооход хэрэглэдэг.
Өөрчлөлт болон үл тасрах/үргэлжилсэн байдал	Түүхийн өөрчлөлт болон үргэлжилсэн байдал нь цаг хугацааны явцад шинэчлэгдэж, өөрчлөгдсөн болон уламжлагдан ирсэн зан заншил, зан үйл, үзэл санаа зэрэг байдаг. Тухайлбал, уламжлал, зан заншил нь өнгөрсөн үед, тодорхой хүчин зүйлсийн нөлөөгөөр бий болсон боловч тодорхой цаг хугацааны туршид хэвээр хадгалагдан үлдсэн байдаг.
Өөрчлөлт	Өнгөрсөн үед бий болсон, бүрэлдэн тогтсон боловч түүхийн цаг хугацааны явцад сайжирсан, хувьсан болон хувирган өөрчилсөн байдал
Цаг тоолол (түүхэн цаг хугацаа)	Цаг хугацааг судлах: Түүхийн үүднээс, цаг тоолол нь үйл явдал, өрнөлийг цаг хугацааны дэс дарааллаар нь харах, ойлгох явдал юм.
Харьцуулалт	Аливаа зүйлс хоорондоо адил төстэй, эсвэл ялгаатай байгааг багцаалах, хэмжих, тэмдэглэх
Тодорхойлох; тайлбарлах	Үйл явдал, тэдгээрийн шинж чанарыг дүрслэх, илэрхийлэх
Боловсруулах	Дэлгэрүүлж, өргөжүүлж, нарийвчлах үйл явц.

Нэр томьёо	Тайлбар
Хөгжил	Хүмүүсийн сайн сайхны тулд эдийн засаг, нийгэм, улс төрийн хүрээнд дэвшилтэт өөрчлөлт хийх, гарах (өөрчлөлтийг харна уу)
Ялган таних	Бүх талыг нь харгалзсан сонголт хийхийн тулд сайтар тунгаан бодсон байх
Зураглах	Бүдүүвчлэх, дүрслэх, бичих зэрэг арга хэлбэрээр тухайн үйл явдлыг найруулах, бүтээх
Баримт нотолгоо	Түүхэн үйл явдлыг сэргээн бүтээх үүднээс түүхэн эх сурвалжаас илрүүлж болох зүйлс (эх сурвалж, анхдагч болон хоёрдогч эх сурвалжийг харна уу).
Тайлбарлах (explanation; explain)	Ойлголт, учир шалтгааны талаарх мэдлэгээ хэрэглэж, баримт жишээтэйгээр мэдээлэх
Хэсэгчилсэн, хагас, дутуу	Уялдаа холбоотой бус, бүрэн бус, нөхцөл байдалд тааруулж хэрэглээгүй.
Шинжлэн судлах (түүхэн)	Өнгөрсөн үед болсон үйл явдлыг ойлгох зорилгоор хийж буй судлах үйл явц. Энэ нь асуулт асуухаас эхлэн эх сурвалжийг олж илрүүлэн, анализ хийх, баримт нотолгоо, мэдээлэлд суурилан өнгөрсөн үеийн талаар тайлбар боловсруулах хүртэлх цогц үйл ажиллагаа.
Тогтоох, олж тогтоох	Хэн, юу, хэзээ гэдгийг олж тогтоох
Мэдээлэлтэй байх	Тухайн сэдвийн талаар мэдлэгтэй, тухайн сэдвийг мэддэг байх
Сайжруулах	Чанарыг сайжруулах, эсвэл илүү тодорхой болгох үүднээс өөрчлөлт хийх, хувиргах, зохилдуулах
Байр суурь	Түүхийн үүднээс авч үзвэл байр суурь гэдэг нь үйлдэл, үйлд баримтлах итгэл үнэмшил, санаа бодлын цогц, эсхүл ертөнцийг үзэх үзэл юм. Байр суурь нь хүн, эсхүл хэсэг бүлгийн нас, хүйс, туршлага, шашин соёл, угсаа гарал, итгэл үнэмшил болон оюуны чадавх зэргээс шалтгаалах бөгөөд тэдний ертөнцийг үзэх үзэл, үзэл бодол, үнэ цэн, үйлдлийг тодорхойлж байдаг. Байр суурийн хоёр хэлбэр байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>- Хүмүүсийн үзэл бодол, байр суурь</li> <li>- Өнгөрсөн болон одоо үеийн үйл явдал, үзэгдлийг харах байр суурь</li> </ul>
Илтгэх	Тодорхой сэдвээр мэдээлэх, тодорхой сэдвийг хөндөх, ялангуяа дүрс, зураг, цахим өгөгдөл, үзүүлэн гэх мэтээр баяжуулсан байх
Анхдагч эх сурвалж	Түүхийн үүднээс анхдагч эх сурвалж гэдэг нь тухайн судалж буй цаг хугацаанд бүтээгдсэн, бичигдсэн эд зүйл, баримт бичиг юм. Жишээлбэл, тодорхой үйл явдал болж байх үед, эсвэл дөнгөж дараахан бүтээгдсэн, бичигдсэн. Үүнд: хууль, гэрээ, хэлцэл гэх мэт албан ёсны бичиг баримтууд, өдрийн тэмдэглэл, захидал, гэрэл зураг, видео бичлэг, хувь хүний бичиг баримт, эд өлгийн зүйлс, амаар ярьсан түүх зэрэг орно. Өнгөрсөн цаг үетэй холбогдолтой асуултад хариулахын (асуудлыг шийдэх) тулд эдгээр анхдагч эх сурвалжуудад шинжилгээ хийдэг (эх сурвалж, хоёрдогч эх сурвалжийг харна уу).
Үйл явц	Тодорхой арга аргачлалын дагуу бэлтгэх, сайжруулах, хоорондоо харилцан уялдаатай, эхэлснээс дуусах хүртэлх алхмаар харуулах
Холбогдолтой, нийцтэй	Логик уялдаа холбоо хамааралтай.
Дараалалд оруулах	Тодорхой дараалалд оруулах. Түүхийн үүднээс дараалалд оруулах гэдэгт он цагийн дараалалд оруулах багтана.
Ач холбогдол	Том зургаар харвал, нийгэм, эсвэл хүмүүсийн хувьд чухал үр дагавар авчирсан, тодорхой хугацаанд үргэлжилсэн, одоо үетэй холбоотой өнгөрсөн үеийн үйл явдал, түүхэн үеийн талаарх байр суурь болон үзэл санаа
Эх/текст	Эхийн тогтсон хэлбэр, хүлээн зөвшөөрөгдсөн байдал нь бидэнд янз бүрийн зорилгоор, янз бүрийн харилцагчидтай үр өгөөжтэйгөөр холбоо харилцаа тогтоож, бусадтай харилцахад тусалдаг. Эх нь амаар, бичгээр, хосолсон, хэвлэмэл эсвэл цахим хэлбэрээр байж болно. Хосолсон эх нь хэлийг харилцаа холбооны бусад системтэй (хэвлэмэл, харагдах дүрс, дуу эгшиг, хэлсэн үг, хальс эсвэл компьютер дээр буулгасан медиа) холбосон байдлыг хэлнэ.

## Хоёр. Үнэлгээний шалгуурыг ашиглан нэгжийн үр дүнг илрүүлэх үнэлгээний даалгавар

Багш нар үнэлгээний нэгжид харгалзах СҮД, түүний шалгуур болон шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшний үзүүлэлтийг ашиглан хичээлийн жилийн сургалтын төлөвлөгөөний дагуу төлөвлөсөн нэгжийн явцын болон үр дүнгийн үнэлгээнд ашиглах даалгаврыг боловсруулах боломжтой. Энэ хэсэгт нэгдүгээр хэсгээр танилцуулсан СҮД-ийн шалгуур, гүйцэтгэлийн түвшний үзүүлэлтийн хүрээнд бага боловсролын IY ангийг сонгон боловсруулсан жишиг даалгаврыг танилцуулж байна.

Сурагчдын гүйцэтгэлийн түвшний үзүүлэлтийг даалгавар бүрээр тодорхойлсон бөгөөд үүнийг СҮД, түүний түвшин, мөн нэр томъёоны тайлбараас тодруулан харж хэрэглэхийг зөвлөж байна. Тухайлбал, IY ангийн 4.2а, 4.2б, 4.2в, суралцахуйн зорилтуудыг “Манай нутгийн онцлог” гэсэн үнэлгээний нэгжид багцлан 2 СҮД-г тодорхойлсон. “Орон нутгийнхаа аж ахуй, үйлдвэрлэл, үйлчилгээний газруудаас сонгон тэдний үйл ажиллагааны талаар мэдээлэл цуглуулж нэгтгэнэ.” гэсэн СҮД-ийн шалгуурыг “Орон нутгийнхаа (сум, дүүрэг, аймаг) аж ахуй, үйлдвэрлэл, үйлчилгээний газруудыг нэрлэж, ангилдаг” гэж тодорхойлно. Иймээс сурагч аль ч түвшинд орон нутгийнхаа үйлдвэр, үйлчилгээний газруудыг нэрлэдэг, ангилдаг болсон.

Сурагчид даалгаврыг “бүрэн, зөв, оновчтой” хийсэн байх нь гүйцэтгэлийн IY түвшний үндсэн үзүүлэлтийг хангаж байгаа бөгөөд “бүрэн, зөв, оновчтой” тухайн даалгаварт өгсөн түүхэн үйл явдалд холбогдох түүхэн хүмүүс, газар нутаг, цаг хугацаа зэргийг оролцуулан нарийвчлан авч үзэж, тодорхой, эх сурвалж, баримтын дагуу бүх талаар зөв гүйцэтгэсэн байна. Харин III түвшний гүйцэтгэлийн хувьд нарийвчлан авч үзээгүй, тодорхой биш боловч ерөнхийд нь бүгдийг гүйцэтгэсэн байна. II түвшний гүйцэтгэл нь сурагч тухайн даалгаврыг хэсэгчилсэн, хагас, дутуу, алдаатай хийсэн байдлаар илэрнэ. Өөрөөр хэлбэл, сурагч тухайн даалгаврыг гүйцэтгэхдээ баримт, эх сурвалжийг ашиглаагүй ба уялдаа холбоотой бус, бүрэн бус, зарим нь алдаатай байна. I түвшний гүйцэтгэлтэй сурагчийн хувьд даалгавар тус бүрийг өгсөн түүхэн нэр томъёо, ойлголтыг

оруулсан өгүүлбэр зохиох, бүдүүвч, газрын зураг дээр алдаатай боловч хийхийг оролдсон байх ёстой. Энэ нь тухайн сурагчийн идэвх зүтгэлийг харуулахын зэрэгцээ багш тухайн сурагчийг цаашид хэрхэн дэмжиж ажиллах талаарх мэдээллийг авна.

### Даалгавар 1.

Үнэлгээний нэгж	Манай нутгийн онцлог
Суралцахуйн үр дүн	Орон нутгийнхаа аж ахуй, үйлдвэрлэл, үйлчилгээний газруудаас сонгон тэдний үйл ажиллагааны талаар мэдээлэл цуглуулж нэгтгэнэ.
Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Орон нутгийнхаа (сум, дүүрэг, аймаг) аж ахуй, үйлдвэрлэл, үйлчилгээний газруудыг нэрлэж, ангилдаг.

Дээрх суралцахуйн үр дүнгийн шалгуурын хүрээнд боловсруулсан даалгавар нь сонгох, зурган мэдээлэлтэй ажиллах, бүдүүвчийг нөхөх, тайлбар бичих 5 ажил бүхий даалгаврыг гүйцэтгэнэ. Эдгээр даалгаврууд хоорондоо холбоотой ба даалгаврыг гүйцэтгэсний үр дүнд орон нутгийнхаа үйлдвэр, үйлчилгээний газруудын явуулж буй үйл ажиллагаа, үйлдвэрлэдэг бараа, бүтээгдэхүүн, ямар мэргэжлийн хүмүүс ажиллаж буйг нэрлэж, ангилж чадаж байгааг илрүүлэх юм.

### Хүснэгт 3. Гүйцэтгэлийн түвшин: Хүн ба нийгэм хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуур


I	II	III	IV
Орон нутгийнхаа аж ахуй, үйлдвэрлэл, үйлчилгээний газруудыг дараах хүрээнд нэрлэж, ангилдаг. Үүнд: – Үйлдвэрлэдэг бараа, үйлчилгээ – Ажиллаж буй хүмүүс	Орон нутгийнхаа аж ахуй, үйлдвэрлэл, үйлчилгээний газруудыг дараах хүрээнд нэрлэж, ангилдаг. Үүнд: – Явуулж буй үйл ажиллагаа – Үйлдвэрлэдэг бараа, үйлчилгээ – Ажиллаж буй хүмүүс	Орон нутгийнхаа аж ахуй, үйлдвэрлэл, үйлчилгээний газруудыг дараах хүрээнд ерөнхийд нь нэрлэж, ангилдаг. Үүнд: – Явуулж буй үйл ажиллагаа – Үйлдвэрлэдэг бараа, үйлчилгээ – Ажиллаж буй хүмүүс	Орон нутгийнхаа аж ахуй, үйлдвэрлэл, үйлчилгээний газруудыг дараах хүрээнд бүрэн нэрлэж, ангилдаг. Үүнд: – Явуулж буй үйл ажиллагаа – Үйлдвэрлэдэг бараа, үйлчилгээ – Ажиллаж буй хүмүүс

Зургийг ажиглан, дараах асуултад хариулна уу.



- Зурагт ямар бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгааг харуулсан бэ?  
А. Хоол, хүнс                      В. Хувцас                      С. Хичээлийн хэрэгсэл                      D. Гутал
- Үйлдвэрт ямар мэргэжлийн хүмүүс ажиллаж байна вэ?
- Бараа, бүтээгдэхүүнийг хаана үйлдвэрлэснийг юунаас мэдэж болох вэ?
- Танай нутагт ямар ямар үйлдвэр, үйлчилгээний газрууд байдгийг нэрлэнэ үү.
- Өгөгдсөн бүтээгдэхүүнийг ангилж, бүдүүвчийг нөхнө үү.





**Хүснэгт 4. Даалгаврын шалгуурын гүйцэтгэлийн түвшний илрүүлэх үзүүлэлт**

Шалгуур	I	II	III	IV
Орон нутгийнхаа (сум, дүүрэг, аймаг) аж ахуй, үйлдвэрлэл, үйлчилгээний газруудыг нэрлэж, ангилдаг.	1-3 дугаар даалгавар: аль нэгэнд хариулахыг оролдсон.  4 дүгээр даалгавар: орон нутагтаа байгаа үйлдвэр, үйлчилгээний газраас тус бүр нэгийг нэрлэсэн.  5 дугаар даалгавар: өгсөн бүдүүвч, үгсийг оновчгүй ч гэсэн хийсэн.	1-3 дугаар даалгавар: аль нэгэнд зөв хариулсан.  4 дүгээр даалгавар: орон нутагтаа байгаа үйлдвэр, үйлчилгээний газраас тус бүр 2-оос доошгүйг нэрлэсэн.  5 дугаар даалгавар: өгсөн бүдүүвчид аль нэг ангиллыг хийж чадсан.	1-3 дугаар даалгавар: ерөнхийд нь хариулсан байна.  4 дүгээр даалгавар: орон нутагтаа байгаа үйлдвэр, үйлчилгээний газраас тус бүр 3-аас доошгүйг нэрлэсэн.  5 дугаар даалгавар: өгсөн бүдүүвчийг ерөнхийд нь хийж, ангилж чадсан байна.	1-3 дугаар даалгавар: бүрэн, зөв хариулсан байна.  4 дүгээр даалгавар: орон нутагтаа байгаа үйлдвэр, үйлчилгээний газраас ихэнхийг нь нэрлэсэн.  5 дугаар даалгавар: өгсөн бүдүүвчийг бүрэн, зөв хийж, ангилж чадсан байна.

Оноо өгөх хүснэгтэн зөвлөмжийг ашиглан сурагчдын гүйцэтгэлийг үнэлэх боломжтой. Үүнийг ашиглахдаа багш сурагчдын гүйцэтгэл бүрийг бүхэл оноогоор үнэлэх, мөн ойролцоо утгатай үгээр хариулж буйг харгалзан хариултын төрөлд оруулж өгөх нь зүйтэй юм.

**Хүснэгт 5. Онооны зөвлөмж**

№	Зөв хариулт	Хариултын төрөл	Оноо
1	Хувцас	Хувцас	1
		Бусад тохиолдолд	0
2	Оёдолчин, хувцас оёдог, нэхмэлчин	Хувцас оёдог, нэхмэлчин	1
		Бусад тохиолдолд	0
3	Шошго	Хувцсыг хэрэглэх заавар, хувцасны хэмжээг харуулсан танилцуулга гэх санааг гаргасан бол	1
		Бусад тохиолдолд	0



4	Зайрмаг, талх, эсгий, ноос ноолуур, банк, сургууль гэх мэт үйлдвэр, үйлчилгээний газар	Нэрлэн бичсэн тохиолдолд	1
		Бусад тохиолдолд	0
5	Хүнс- талх, боов, зайрмаг Үйлдвэр- ноосон цамц, малгай, оймс Үйлчилгээ- банк, үсчин, номын сан	Өгсөн үгсийг бүдүүвчид зөв ангилсан бол	9
		Өгсөн үгсээс бүдүүвчид 8-ыг зөв ангилсан бол	8
		Өгсөн үгсээс бүдүүвчид 7-г зөв ангилсан бол	7
		Өгсөн үгсээс бүдүүвчид 6-г зөв ангилсан бол	6
		Өгсөн үгсээс бүдүүвчид 5-ыг зөв ангилсан бол	5
		Өгсөн үгсээс бүдүүвчид 4-ийг зөв ангилсан бол	4
		Өгсөн үгсээс бүдүүвчид 3-ыг зөв ангилсан бол	3
		Өгсөн үгсээс бүдүүвчид 2-ийг зөв ангилсан бол	2
		Өгсөн үгсээс бүдүүвчид 1-ийг зөв ангилсан бол	1
		Бусад тохиолдолд	0

**Даалгавар 2.***Үнэлгээний нэгж*

Манай нутгийн онцлог

*Суралцахуйн үр дүн*

Орон нутгийнхаа аж ахуй, үйлдвэрлэл, үйлчилгээний газруудаас сонгон тэдний үйл ажиллагааны талаар мэдээлэл цуглуулж нэгтгэнэ.

*Суралцахуйн үр дүнгийн шалгуур*


Орон нутгийнхаа соёлын болон үйлчилгээний (номын сан, музей, дэлгүүр, үсчин, эмийн сан г.м) газруудаас сонгон түүнийхээ талаар мэдээлэл цуглуулж нэгтгэдэг.

Даалгавар нь зурган мэдээлэлтэй ажиллах, тайлбар бичих таван ажилтай. Тухайлбал, 4 дүгээр ажил нь сурагчид мэдээллийг цуглуулж чадаж байгаа бол 5 дугаар ажил нь 1-4 дүгээр ажлын гүйцэтгэлийг нэгтгэж танилцуулга хийж байгааг илрүүлэхээр юм.

**Хүснэгт 6. Гүйцэтгэлийн түвшин: Хүн ба нийгэм хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуур**

I	II	III	IV
Орон нутгийнхаа соёлын болон үйлчилгээний газраас сонгон түүнийхээ талаар мэдээлэл цуглуулан нэгтгэхийг оролддог.	Орон нутгийнхаа соёлын болон үйлчилгээний газраас сонгон түүнийхээ талаар дараах асуултын дагуу мэдээлэл цуглуулж нэгтгэдэг. Үүнд: – Ямар үйлчилгээний газрууд байдаг вэ? – Бидэнд ямар үйлчилгээ үзүүлдэг вэ?	Орон нутгийнхаа соёлын болон үйлчилгээний газраас сонгон түүнийхээ талаар дараах асуултын дагуу мэдээлэл цуглуулж нэгтгэдэг. Үүнд: – Ямар үйлчилгээний газрууд байдаг вэ? – Бидэнд ямар үйлчилгээ үзүүлдэг вэ? – Ямар мэргэжлийн хүмүүс ажилладаг вэ?	Орон нутгийнхаа соёлын болон үйлчилгээний газраас сонгон түүнийхээ талаар дараах асуултын дагуу мэдээлэл цуглуулж нэгтгэдэг. Үүнд: – Ямар үйлчилгээний газрууд байдаг вэ? – Бидэнд ямар үйлчилгээ үзүүлдэг вэ? – Ямар мэргэжлийн хүмүүс ажилладаг вэ? – Ямар ажил хийдэг вэ?

Дараах үйлчилгээний газруудаас нэгийг сонгон асуултад хариулна уу.



1. Сонгосон үйлчилгээний газрынхаа нэрийг бичнэ үү.
2. Таны сонгосон үйлчилгээний газар хүмүүст ямар үйлчилгээ үзүүлдэг вэ?
3. Тэр газарт ямар мэргэжлийн хүмүүс ажилладаг вэ?
4. 2 ба 3 дугаар асуултад хариулахын тулд мэдээллийг хаанаас, хэрхэн цуглуулж болох вэ?
5. Үе тэнгийнхэндээ зориулан сонгосон газрынхаа тухай танилцуулга бичнэ үү.

**Хүснэгт 7. Даалгаврын шалгуурын гүйцэтгэлийн түвшний илрүүлэх үзүүлэлт**

Шалгуур	I	II	III	IV
Орон нутгийнхаа соёлын болон үйлчилгээний (номын сан, музей, дэлгүүр, үсчин, эмийн сан гэх мэт) газруудаас сонгон түүнийхээ талаар мэдээлэл цуглуулж нэгтгэдэг.	<p>1 дүгээр даалгавар: үйлчилгээний газрыг сонгон нэрийг бичсэн.</p> <p>2-3 дугаар даалгавар: ямар үйлчилгээ үзүүлдэг, ямар мэргэжилтэй хүмүүс ажилладаг зэргээс 1-ийг нэрлэсэн.</p> <p>4 дүгээр даалгавар: мэдээллийн эх сурвалж, мэдээлэл авах арга зам зэргээс 1-ээс доошгүйг тодорхойлсон.</p> <p>5 дугаар даалгавар: сонгосон газрынхаа явуулж буй үйл ажиллагаа, ямар мэргэжлийн хүмүүс ажилладаг зэргээр танилцуулгыг бичихийг оролдсон.</p>	<p>1 дүгээр даалгавар: үйлчилгээний газрыг сонгон нэрийг бичсэн.</p> <p>2-3 дугаар даалгавар: ямар үйлчилгээ үзүүлдэг, ямар мэргэжилтэй хүмүүс ажилладаг зэргээс 2-оос доошгүйг нэрлэсэн.</p> <p>4 дүгээр даалгавар: мэдээллийн эх сурвалж, мэдээлэл авах арга зам зэргээс 2-оос доошгүйг тодорхойлсон.</p> <p>5 дугаар даалгавар: сонгосон газрынхаа явуулж буй үйл ажиллагаа, ямар мэргэжлийн хүмүүс ажилладаг зэргээр танилцуулгыг товч бичсэн.</p>	<p>1 дүгээр даалгавар: үйлчилгээний газрыг сонгон нэрийг бичсэн.</p> <p>2-3 дугаар даалгавар: ямар үйлчилгээ үзүүлдэг, ямар мэргэжилтэй хүмүүс ажилладаггүйг ерөнхийд нь нэрлэсэн.</p> <p>4 дүгээр даалгавар: мэдээллийн эх сурвалж, мэдээлэл авах арга зам зэргээс 3-аас доошгүйг тодорхойлсон.</p> <p>5 дугаар даалгавар: сонгосон газрынхаа явуулж буй үйл ажиллагаа, ямар мэргэжлийн хүмүүс ажилладаг, ямар үйлчилгээ үзүүлдэг зэргээр танилцуулгыг ерөнхийд нь бичсэн.</p>	<p>1 дүгээр даалгавар: үйлчилгээний газрыг сонгон нэрийг бичсэн.</p> <p>2-3 дугаар даалгавар: ямар үйлчилгээ үзүүлдэг, ямар мэргэжилтэй хүмүүс ажилладаггүйг бүрэн нэрлэсэн.</p> <p>4 дүгээр даалгавар: мэдээллийн эх сурвалж, мэдээлэл авах арга зам зэргийг зөв тодорхойлсон.</p> <p>5 дугаар даалгавар: сонгосон газрынхаа явуулж буй үйл ажиллагаа, ямар мэргэжлийн хүмүүс ажилладаг, ямар үйлчилгээ үзүүлдэг зэргээр танилцуулгыг бүрэн бичсэн.</p>

**Даалгаврын гүйцэтгэлийн түвшнийг илрүүлэх үзүүлэлт**

Дээрх үйлчилгээний байгууллагаас номын санг сонгон жишээ болгон хариултын мэдээлэл болон оноожуулалтыг харуулж байна.

**Хүснэгт 8. Зөв хариултын онооны зөвлөмж**

№	Зөв хариулт	Хариултын төрөл	Оноо
1	Номын сан	Номын сан	1
		Бусад тохиолдолд	0
2	Сурах бичиг, үлгэрийн болон бусад ном зохиолыг уншдаг газар	Сурах бичиг, үлгэрийн болон бусад ном зохиолыг уншдаг газар	1
		Бусад тохиолдолд	0
3	Номын санч, үйлчлэгч гэх мэт	Номын санч, үйлчлэгч гэх мэт	1
		Бусад тохиолдолд	0
4	Мэдээллийг интернет, телевиз, ном, сонин, аав, ээж, ах, эгч, найз гэх мэт ярилцлага хийх	Мэдээлэл олж авах эх сурвалж, арга замаа бичсэн бол	1
		Бусад тохиолдолд	0
5	Зурган болон бичмэл танилцуулгыг хийсэн бол	Зурган болон бичмэл танилцуулгыг хийсэн бол	1
		Бусад тохиолдолд	0

**Даалгавар 3.***Үнэлгээний нэгж*

Манай нутгийн онцлог

*Суралцахуйн үр дүн*

Нутгийнхаа хүмүүсийн аж амьдрал, соёлын онцлогийг танилцуулна.

*Суралцахуйн үр дүнгийн шалгуур*

Нутгийнхаа хүмүүсийн ахуй амьдрал, эрхлэх гол аж ахуйн талаар жишээ баримт, газарзүйн зураг ашиглан танилцуулдаг.

Даалгавар нь газарзүйн зурагтай ажиллах, загварыг ашиглан тайлбар бичих дөрвөн ажилтай. Эдгээр даалгаврууд хоорондоо холбоотой бөгөөд сурагчид даалгаврыг гүйцэтгэсний үр дүнд орон нутгийнхаа хүмүүсийн эрхэлдэг аж ахуй, газар нутгийн онцлогийг танилцуулж чаддаг болсон байхаар боловсруулсан.

**Хүснэгт 9. Гүйцэтгэлийн түвшин: Хүн ба нийгэм хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуур**

I	II	III	IV
Өөрийн орон нутгийнхаа хүмүүсийн голлон эрхэлдэг аж ахуйг танилцуулдаг.	Өөрийн орон нутгийнхаа хүмүүсийн голлон эрхэлдэг аж ахуйг дараах агуулгын хүрээнд танилцуулдаг. Үүнд: – Голлон эрхэлдэг аж ахуй – Газар нутгийн онцлог	Өөрийн орон нутгийнхаа хүмүүсийн голлон эрхэлдэг аж ахуйг жишээ баримттайгаар дараах агуулгын хүрээнд ерөнхийд нь танилцуулдаг. Үүнд: – Голлон эрхэлдэг аж ахуй – Газар нутгийн онцлог	Өөрийн орон нутгийнхаа хүмүүсийн голлон эрхэлдэг аж ахуйг жишээ баримттайгаар дараах агуулгын хүрээнд бүрэн танилцуулдаг. Үүнд: – Голлон эрхэлдэг аж ахуй – Газар нутгийн онцлог

Дараах газарзүйн зургийг ажиглан асуултад хариулаарай.



1. Өөрийн амьдардаг газар нутгийг газар зүйн зурагт тэмдэглэнэ үү.
2. Танай нутгийн хүмүүс голлон ямар аж ахуй эрхэлдэг вэ?
 

A. Газар тариалан	B. Мал аж ахуй
C. Үйлдвэр, үйлчилгээ	D. Уул уурхай
3. Зургийг ажиглан өөрийн амьдардаг газрыг сонгоно уу.



4. Өгсөн загварыг ашиглан өөрийн амьдардаг орон нутгийнхаа онцлогийг танилцуулна уу.

Манай нутаг Монгол улсын ..... хэсэгт оршдог.

Манай нутгийн газрын гадарга нь ..... байдаг.

Манай нутаг ..... бараа, бүтээгдэхүүн алдартай.

Манай нутаг ..... дурсгалын газруудтай.

Манай нутаг ..... үзэсгэлэнтэй газартай.

Манай нутаг ..... илүү их хөгжсөн.

*Ашиглах зарим үгс:* (баруун, зүүн, төв, уулархаг, талархаг, цагаан идээ, чацаргана, чихэр, талх, нарийн боов, түүх, соёл, байгаль, уул, ус, мод, нуур, мал аж ахуй, газар тариалан, уул уурхай)

**Хүснэгт 10. Даалгаврын шалгуурын гүйцэтгэлийн түвшний илрүүлэх үзүүлэлт**

Шалгуур	I	II	III	IV
Нутгийнхаа соёл, хүмүүсийн амьдралын онцлогийг газарзүйн зураг, мэдээлэл, эх сурвалж ашиглан танилцуулдаг.	1 ба 2 дугаар даалгавар: газар зүйн зурагт тэмдэглэх, орон нутгийнхаа голлох аж ахуйг нэрлэсэн ч оновчгүй хариулсан.  3 ба 4 дүгээр даалгавар: өөрийн амьдардаг газраа сонгон орон нутгийнхаа онцлогийг загварын дагуу 2-оос доошгүйг зөв нөхөж бичсэн.	1 ба 2 дугаар даалгавар: газар зүйн зурагт тэмдэглэх, орон нутгийнхаа голлох аж ахуйг нэрлэсэн.  3 ба 4 дүгээр даалгавар: өөрийн амьдардаг газраа сонгон орон нутгийнхаа онцлогийг загварын дагуу 3-аас доошгүйг зөв нөхөж бичсэн.	1 ба 2 дугаар даалгавар: газар зүйн зурагт тэмдэглэх, орон нутгийнхаа голлох аж ахуйг ерөнхийд нь нэрлэсэн.  3 ба 4 дүгээр даалгавар: өөрийн амьдардаг газраа сонгон орон нутгийнхаа онцлогийг загварын дагуу ерөнхийд нь бичсэн.	1 ба 2 дугаар даалгавар: газар зүйн зурагт тэмдэглэх, орон нутгийнхаа голлох аж ахуйг зөв нэрлэсэн.  3 ба 4 дүгээр даалгавар: өөрийн амьдардаг газраа сонгон орон нутгийнхаа онцлогийг загварын дагуу бүрэн, дэлгэрүүлж бичсэн.

**Хүснэгт 11. Онооны зөвлөмж**

№	Зөв хариулт	Хариултын төрөл	Оноо
1	Өөрийн амьдардаг газраа зөв тэмдэглэх	Зөв тэмдэглэсэн бол	1
		Бусад тохиолдол	0
2	Газар тариалан, мал аж ахуй, үйлдвэр, үйлчилгээ, уул уурхай	Зөв сонгосон бол	1
		Бусад тохиолдол	0
3	Төв суурин, хөдөө орон нутаг	Зөв нэрлэсэн бол	1
		Бусад тохиолдол	0
4	Дараах үгсийг ашиглан цэгийн оронд дэлгэрүүлж бичсэн. (баруун, зүүн, төв, уулархаг, талархаг, цагаан идээ, чацаргана, чихэр, талх, нарийн боов, түүх, соёл, байгаль, уул, ус, мод, нуур, мал аж ахуй, газар тариалан, уул уурхай)	Загварыг зөв нөхөж бичсэн бол	6
		5 үг зөв нөхөж бичсэн бол	5
		4 үг зөв нөхөж бичсэн бол	4
		3 үг зөв нөхөж бичсэн бол	3
		2 үг зөв нөхөж бичсэн бол	2
		1 үг зөв нөхөж бичсэн бол	1
		Бусад тохиолдол	0

# ҮНЭЛГЭЭНИЙ ДААЛГАВРЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ШИНЖЛЭХДЭЭ ДААЛГАВАРТ БУС, ДААЛГАВРЫН ГҮЙЦЭТГЭЛД АЧ ХОЛБОГДОЛ ӨГЧ, ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮВШНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ДАГУУ ШИНЖЛЭХИЙГ ЗӨВЛӨЖ БАЙНА.

Үнэлгээний даалгаврын гүйцэтгэлийг шинжлэхдээ даалгаварт бус, даалгаврын гүйцэтгэлд ач холбогдол өгч, гүйцэтгэлийн түвшний шалгуур үзүүлэлтийн дагуу шинжлэхийг зөвлөж байна. Ингэснээр багш даалгаврыг сайжруулах хэрэгтэй гэж үзвэл юуг, хэрхэн өөрчилж ойлгомжтой болгохыг тодорхой харах юм. Багш даалгаврын гүйцэтгэлийг шинжлэхдээ дараах алхмаар ажиллахыг та бүхэндээ зөвлөж байна.

- Даалгаврын зөв, оновчтой хариулт, хувилбарыг гаргах хэрэгтэй. Үүнд: 2 дугаар хэсэгт танилцуулсан гүйцэтгэлийн түвшний үзүүлэлт болон оноо өгөх зөвлөмжийг ашиглах боломжтой.
- Тухайн хариулт болон 2 дугаар хэсэгт танилцуулсан “Даалгаврын шалгуурын гүйцэтгэлийн түвшнийг илрүүлэх үзүүлэлт”-ийг ашиглан сурагчдын гүйцэтгэлийг үнэлнэ. Ингэхдээ дараах үнэлгээний загвар хуудсыг ашиглаж болох юм.

## Хүснэгт 12. Үнэлгээний даалгаврын гүйцэтгэл, шинжилгээ (загвар)

№	Сурагч	Даалгавар	Гүйцэтгэлийн түвшин				Үнэлгээний үндэслэл/тэмдэглэл (алдааны шинжилгээ)
			I	II	III	IV	
1.	Сурагч 1	1		+			<ul style="list-style-type: none"> <li>- I, II түвшинд гүйцэтгэсэн даалгаврын тухайд, тухайн даалгаврыг гүйцэтгэхийг оролдсон боловч тухайлан юу, яагаад буруу, оновчгүй, алдаатай хийснийг тэмдэглэнэ.</li> <li>- Мөн тухайн даалгаврыг зөв, оновчтой болгохын тулд сурагчид ямар дэмжлэг үзүүлж болох, ямар хэрэглэгдэхүүн ашиглаж болохыг тэмдэглэнэ.</li> <li>- III түвшинд гүйцэтгэсэн даалгаврын тухайд сурагч нарийвчилсан болон тодорхой хариулах, гүйцэтгэхтэй холбоотой анхаарах зүйлсийг тэмдэглэнэ.</li> </ul>
		2			+		
		3	+				
		4	+				
		5			+		

Үнэлгээний даалгаврын гүйцэтгэл, шинжилгээ бүхий дээрх хуудсыг сурагч бүр дээр үнэлгээний нэгж бүрээр хөтөлж болно. Энэ нь тухайн сурагчийн ахиц амжилт, СҮД-ийн шалгуурыг хангаж буй үйл явцыг танд харуулна. Мөн үнэлгээний нотлох баримт болох ач холбогдолтой.

в) Сурагчдын гүйцэтгэлийн түвшин, үнэлгээний үндэслэл зэргээ ашиглан тухайн сурагчид үзүүлэх дэмжлэг, зөвлөгөө болон түүнд зориулсан хэрэглэгдэхүүнийг боловсруулах, бэлэн хэрэглэгдэхүүнийг ялган бэлтгэх, хэрхэн тухайн сурагчтайгаа хамтран ажиллахаа төлөвлөнө. Энэ нь сурагчийн гүйцэтгэлд шинжилгээ хийсний гол үр дүн юм. Тухайлбал, I, II түвшний гүйцэтгэлтэй сурагчийн эцэг, эхийн хамтаар уулзаж, цаашид хамтран ажиллах төлөвлөгөө, үнэлгээг танилцуулан хичээлийн төлөвлөлтөө хийх хэрэгтэй. Энэ нь сурагчийн алдаан дээрээ суралцах боломжийг олгоно.

Дээр санал болгосон алхмуудын дагуу бага боловсролын IY ангийн “Манай нутгийн онцлог” үнэлгээний нэгжийн хүрээнд боловсруулсан 1 дүгээр даалгаврын гүйцэтгэлийн шинжилгээ, түүний үр дүнг хэрэглэх арга замыг жишээ болгон харуулж байна.

а) *Даалгаврын ажлуудын зөв, оновчтой хариулт, хувилбар*

1. Зурагт ямар бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгааг харуулсан бэ?

A. Хоол, хүнс

B. Хувцас

C. Хичээлийн хэрэгсэл

D. Гутал

2. Үйлдвэрт ямар мэргэжлийн хүмүүс ажиллаж байна вэ?

Оёдолчин, хувцас оёдог, нэхмэлчин гэх мэт


3. Бараа, бүтээгдэхүүнийг хаана үйлдвэрлэснийг юунаас мэдэж болох вэ?

Шошго (хаяг) –оос мэдэж болно.

4. Танай нутагт ямар, ямар үйлдвэр, үйлчилгээний газрууд байдгийг нэрлэнэ үү.

*Талх, нарийн боовны үйлдвэр, ноос, ноолууран хувцасны үйлдвэр, цэвэр усны үйлдвэр гэх мэт. Хүнсний дэлгүүр, банк, эмнэлэг, сургууль, үсчин, номын сан, тоглоомын газар гэх мэт.*

5. Өгөгдсөн бүтээгдэхүүнийг ангилж, бүдүүвчийг нөхнө үү.



(Ангилах бүтээгдэхүүн: ноосон цамц, талх, малгай, чихэр, оймс, банк, үсчин, давс, номын сан)

б) *Сурагчдын ажлын гүйцэтгэл, алдааны шинжилгээ*

Өмнөх хэсэгт танилцуулсан ажлуудыг зөв, оновчтой хариулт болон энэхүү зөвлөмжийн 2 дугаар хэсэгт танилцуулсан “Даалгаврын шалгуурын гүйцэтгэлийн түвшний илрүүлэх үзүүлэлт”-ийг ашиглан сурагчдын ажлыг үнэлнэ. Дараах жишээг та бүхэнд санаа өгөх үүднээс хийсвэр байдлаар танилцуулж байна.



**Хүснэгт. Үнэлгээний даалгаврын гүйцэтгэл, шинжилгээ (загвар)**

№	Сурагч	Даалгавар	Гүйцэтгэлийн түвшин				Үнэлгээний үндэслэл/тэмдэглэл (алдааны шинжилгээ)	
			I	II	III	IV		
1.	Сурагч 1	1		+			Зурган мэдээллийг ажиглан ямар бүтээгдэхүүн үйлдвэрлэж буйг оновчгүй хариулсан.	Зурагт үзүүлэнтэй ажиллуулах, түүнийг нэрлүүлэх, ялгуулах
		2			+		Үйлдвэрт ямар мэргэжилтэй хүмүүс ажилладгийг ерөнхийд нь нэрлэсэн.	Үйлдвэр, үйлчилгээний газарт ямар мэргэжлийн хүмүүс ажилладаг болон онцлогийг тайлбарлаж өгөх
		3	+				Бараа, бүтээгдэхүүн хаана үйлдвэрлэснийг нэрлэх гэж оролдсон.	ТӨМ бэлтгэн сурагчдад таниулах Цахим орчноос мэдээлэл уншиж, түүнийгээ тайлбарлах
		4	+				Орон нутгийнхаа үйлдвэр, үйлчилгээний газруудыг нэрлэх гэж оролдсон.	Үйлдвэр болон үйлчилгээний газрын ялгаатай болон төсөөтэй талыг тайлбарлаж өгөх, нэрлүүлэх
		5		+			Өгөгдсөн бүдүүвчийн дагуу алдаатай, хагас, дутуу оноож бөглөсөн.	Багш төрөл бүрийн үг бичсэн картаас үйлдвэр, үйлчилгээний төрлөөр ангилуулах, ялгуулах

в) Алдааны шинжилгээний үндсэн дээр сурагчидтай ажиллах нь

Өмнөх хэсэгт алдааны шинжилгээ хийсэн 1 даалгаврыг жишээ болгон тухайн сурагчтай хэрхэн ажиллах талаар танилцуулж байна. Энэхүү даалгаварт алдааны шинжилгээ хийснээр сурагч 1-д дэмжлэг үзүүлж, СҮД-ийн шалгуурыг хангадаг болоход нь туслах юм.

Сурагч 1-ийн алдаан дээр суралцах төлөвлөгөө (жишээ байдлаар-ерөнхий)

Хөгжүүлэх чадвар – хүрсэн байх үр дүн	Үйл ажиллагаа			Хугацаа
	багш	сурагч	хамтран	
Зургаас асуултын дагуу, тодорхой мэдээллийг олж чаддаг болно.	- Аргачлал, удирдамж, зөвлөгөө бэлтгэнэ. - Холбогдох хэрэглэгдэхүүнийг сонгож сурагчид санал болгоно.	- Багшийн аргачлалын дагуу сонгосон зургаас асуултын дагуу мэдээллийг ялгана.	- Сурагчийн гүйцэтгэлийг хэлэлцэнэ. Тухайлбал, сурагч ажлаа танилцуулж, багш асууна. Шаардлагатай зөвлөгөөг өгнө.	7 хоногт ...-ээс доошгүй мэдээлэл дээр ажиллана.
Хүснэгтэн мэдээлэлтэй ажиллаж чаддаг болно.	- Эцэг, эх, асран хамгаалагчид танилцуулж, хамтран ажиллахыг санал болгоно.			



## Тэмдэглэл

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

**ЕБС-ийн Хүн ба нийгэм хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг хэрэглэх зөвлөмж боловсруулсан ажлын хэсэг:**

У.Туяа	Боловсролын хүрээлэнгийн секторын эрхлэгч, доктор (Ph.D)
Д.Янжинжав	Боловсролын үнэлгээний төвийн мэргэжилтэн, магистр

**Хөндлөнгийн шинжээч:**

Ч.Гажиддулам	БМДИ-ийн арга зүйч, магистр
--------------	-----------------------------

**Техникийн редактор:**

М.Болдсайхан	Боловсролын үнэлгээний төвийн хэлтсийн дарга
Ш.Сувдмаа	Боловсролын үнэлгээний төвийн мэргэжилтэн, магистр

**Хэвлэлийн эх бэлтгэсэн дизайнер:**

С.Мөнхмаа	Интерпресс ХХК-ийн дизайнер, магистр
-----------	--------------------------------------

**Цаасны хэмжээ:** А4

**Хэвлэлийн хуудас:** 3 х.х



*Дэлгэрэнгүй мэдээллийг:*

[www.eec.mn](http://www.eec.mn)



Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 6-р хороо,  
Энхтайваны өргөн чөлөө, Оюуны ундраа группын байр,  
Утас/Факс: 976-11 7011- 8486  
И-майл: [info@eec.mn](mailto:info@eec.mn) Вэб: [www.eec.mn](http://www.eec.mn)